



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

2025 оныг “Иргэдийн итгэлийг хүлээсэн
төрийн үйлчилгээний жил” болгон зарлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор 2025 оныг “Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил” болгон зарласугай.

2.“Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой зорилт, арга хэмжээгээр тусгаж, хэрэгжүүлж ажиллахыг нэгжийн дарга, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.“Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор боловсруулан батлуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Энхболд)-т даалгасугай.

5.“Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны явц, үр дүнг улирал тутам Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулж, олон нийтэд тогтмол мэдээлж, сурталчилан ажиллахыг Ажлын хэсэг (Б.Энхболд)-т үүрэг болгосугай.

ДАРГА  А.ЭНХМАНЛАЙ



1525010043

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн
ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр
сарын 02-ны өдрийн 11/2 дугаар
тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга: Б.Энхболд	Төрийн захиргаа, удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ажлын хэсгийн дэд дарга: П.Баянтүмэн	Кадастрын хэлтсийн дарга
Ажлын хэсгийн нарийн бичиг: Э.Дулмаа	Төрийн захиргаа, удирдлагын газрын мэргэжилтэн
Ажлын хэсгийн гишүүд: А.Амарсайхан	Газрын судалгаа шинжилгээ, бодлого төлөвлөлтийн газрын дарга
Ж.Гал	Орон зайн өгөгдөл, дэд бүтцийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ц.Ихбаяр	Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга
Г.Халиунбигэр	Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга
Д.Түвшинбат	Салбарын хяналт шалгалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Дөл	Газрын мониторингийн хэлтсийн дарга
Ш.Мандахзул	Газрын биржийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Д.Мөнхцэцэг	Геодези, зураг зүйн хэлтсийн дарга
П.Нямдаваа	Мэдээлэл, технологийн хэлтсийн дарга
Б.Батмягмар	Салбарын архивын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Г.Мөнхбаатар	Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ч.Отгонжаргал	Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Д.Алтангэрэл	Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Ж.Естай	Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Ү.Бямбасүрэн	Булган аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Ж.Мянганбаяр	Говь-Алтай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Отгончимэг	Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Д.Батчулуун	Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Д.Дамдинбазар	Дорнод аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Л.Олзбаяр	Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Э.Чагнаадорж	Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Э.Балжинням	Завхан аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Д.Цолмон	Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Т.Ариунболд	Өвөрхангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
П.Золжаргал	Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Э.Төгөлдөр	Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Б.Саруултөгс	Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
С.Нямжав	Увс аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Насанжаргал	Төв аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Б.Шинэзориг	Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Ганзориг	Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Б.Сүнгээ	Хэнтий аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/54

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил"-ийн хүрээнд салбарын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээг үр дүнтэй, чанартай зохион байгуулж ажиллахыг ерөнхий газрын нэгжийн дарга, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга нарт тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Энхболд)-т үүрэг болгосугай.

ДАРГА



А.ЭНХМАНЛАЙ

1525010199



Газар зохион байгуулалт, геодэзи зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн дугаар тушаалын хавсралт

“ИРГЭДИЙН ИТГЭЛИЙГ ХҮЛЭЭСЭН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

№	Арга хэмжээ	Хугацаа (сар)	Хариуцах газар, хэлтэс		Тайлбар
			Үндсэн	Хамтран	
Нэг. Салбарын хууль, тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчлах					
1.	“Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил”-ийн өнгө төрхийг илэрхийлсэн лого, жижиг хэмжээний бренд бүк /brandbook/ гаргана;	II	ТЗУГ	ГСШБТГ	Байгууллагаас 2025 онд зохион байгуулах арга хэмжээний танилцуулга, анонс гэх мэт нь нэгдсэн өнгө төрхтэй болно.
2.	Салбар, орон нутгийн хэмжээнд “Төрийн байгууллагад шинээр томилогдсон албан хаагчдад ажлын чиг баримжаа олгох, байгууллагын соёл, үйл ажиллагаанд дадлагажуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх;	I-XII	ТЗУГ	21 аймгийн ГХБХБГ, НГЗБА	-
3.	Цахимд суурилсан газрын нэгдсэн лавлах 1800-0101 үйлчилгээг хиймэл оюун ухаанд суурилсан виртуал операторын системд шилжүүлэх;	III	ТЗУГ	Чимэгэ системс	-
4.	Салбарын хэмжээнд ирсэн өргөдөл, гомдлыг эцэслэн шийдвэрлэх аян зохион байгуулах;	I-XII	ТЗУГ	21 аймгийн ГХБХБГ, НГЗБА	-
5.	Газрын харилцааны бүтээгдэхүүн, үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд хүргэх киоск төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл, чанарыг сайжруулах, тоо, хүртээмжийг нэмэгдүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах;	I-XII	МТХ	21 аймгийн ГХБХБГ, НГЗБА	Газрын харилцааны бүтээгдэхүүн, үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд хүргэх киоск төхөөрөмжүүдийн хэрэглээ, боломж,

					байршил зэрэг мэдээллийг байгууллагын олон нийтийн сүлжээ /Facebook/-ээр сар бүр 1-2 удаа сурталчлах ажлыг зохион байгуулна.
					Улсын хэмжээнд нийт 330 сумдын даамлаас эхний ээлжинд 20 сумдын даамлыг Засгийн газрын 2002 оны “Зардлын норматив, нийтлэг жишиг батлах тухай” 120 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг”-ийн дагуу төрийн албан хаагчийн нийтлэг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлөөр хангаж, бодит хэрэгцээ шаардлагад тулгуурлан үе шаттайгаар сайжруулна.
6.	Салбарын хэмжээнд хууль тогтоомжоор хэрэгжүүлэх чиг үүргийг хэвийн, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжэй, түргэн шуурхай хүргэх зорилгоор аймгийн ГХБХБГ-ын даамлуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, шаардлагатай тавилга, багаж, техник хэрэгслээр хангах;	III-IX	СЭЗХ	21 аймгийн ГХБХБГ	
7.	Газрын удирдлагын нэгдсэн цахим систем (egazar.gov.mn)-ээр дамжуулан иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэх үйл ажиллагааг иргэдэд ойлгомжтой байдлаар тайлбарласан видео, контент хийж олон	I-XII	ГЗБГЗЗБГ	21 аймгийн ГХБХБГ, НГЗБА	-

	нийтийн сүлжээгээр түгээх ажлыг зохион байгуулах;					
8.	Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хаягуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслүүдийн талаар төрийн болон мэргэжлийн төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачид, иргэд олон нийтийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулах;	IV-V	ГЗБГЗЗЕГ	21 аймгийн ГХБХБГ, НГЗБА	-	
9.	“Бид иргэдээ сонсож, шийднэ” өдрийг зохион байгуулж, хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлыг хэвшүүлэх;	I-XII	ГЗБГЗЗЕГ	Төрийн албаны зөвлөл, 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА		
10.	Иргэдээс харьяалах төрийн үйлчилгээний чиглэлээр судалгаа авч, хэрэгжүүлбэл зохих, тулгамдаж буй асуудлыг эрэмбэлэн тодорхойлж, шинэлэг бүтээлч шийдлээр хэрэгжүүлэх арга хэмжээ авах;	I-XII	ГЗБГЗЗЕГ	Төрийн албаны зөвлөл, 21 аймгийн ГХБХБГ, НГЗБА		
11.	Хаягийн мэдээллийн системд бүртгэгдээгүй нэгж талбар, барилгад хаяг олгох ажлыг зохион байгуулах, хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;	IV-XII	КХ	21 аймгийн ГХБХБГ, НГЗБА	Хаягийг автоматаар олгох шинэ системийг хэрэглээнд нэвтрүүлж, хаяг түргэн шуурхай авах боломжийг нэмэгдүүлнэ.	
12.	Төрийн байгууллагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэн, үйлчлүүлэхэд саадгүй зорчих орчин нөхцөлөөр хангах	I-XII	ТЗУГ	21 аймгийн ГХБХБГ, НГЗБА	Иргэдэд тэгш хүртээмжтэй үйлчилгээг хүртээх зорилготой	
13.	Салбарын хэмжээнд албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлага, хууль эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;	I-IV	ГЗБГЗЗЕГ	21 аймгийн ГХБХБГ, НГЗБА	Ёс зүйтэй мэдлэгтэй албан хаагч үйлчилгээг түргэн шуурхай, чанартай үзүүлнэ.	

14.	“Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил” нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах;	V/01	ГЗБГЗЗЕГ	21 аймгийн ГХБХБГ, НГЗБА	-
15.	“Зөрчилгүй дүүрэг” арга хэмжээний хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт газрын зөрчлийн судалгааг гаргаж, батлагдсан удирдамжийн дагуу зөрчил арилгах арга хэмжээг зохион байгуулж, хяналт тавих	I-IV	СХШХ	21 аймгийн ГХБХБГ, НГЗБА	-
Хоёр. Цахим системийн үйлчилгээ нэвтрүүлэх ажлын талаар					
16.	Иргэд, олон нийтийг “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлт”-ийн цахим системээр дамжуулан бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хялбар байдлаар санал өгөх боломжийг бүрдүүлсэн модулийг цахим системд хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;	III улирал	ГЗБХ	21 аймгийн ГХБХБГ, НГЗБА	-
17.	Газар, геодези, зураг зүйн хяналт шалгалтын цахим системийг хэрэглээнд нэвтрүүлж, иргэдээс газартай холбоотой гаргасан санал, гомдлыг цахимаар хүлээн авч шалган шийдвэрлэх, хяналт, шалгалтын үр дүнг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх;	II-XII	СХШХ	21 аймгийн ГХБХБГ, НГЗБА	Газар, геодези, зураг зүйн хяналт шалгалтын системээр дамжуулан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн бүх төрлийн хяналт шалгалтын мэдээллийг нээлттэй, ил тод болгох
18.	Геоидын өндрийн загвар ашиглах, солбицол хоорондын хөрвүүлэг хийх цахим үйлчилгээг иргэд, олон нийтэд тайлбарлаж, танилцуулах ажлыг зохион байгуулах;	IV-XII	ГЗЗХ	-	-
19.	Геодезийн хэмжлийн багаж баталгаажуулах цахим системд оруулах эталон утгыг хэмжиж тодорхойлох, холбогдох хурлаар хэлэлцүүлэх, батлуулах, цахим системийг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд ашиглуулах;	II-XII	ГЗЗХ	-	-
20.	GNSS-ийн статик хэмжилтийн өгөгдлийг ITRF2020 тогтолцоонд тэгшитгэн бодох цахим системийг шинэчлэн хөгжүүлэх ажлын даалгавар	II-XII	ГЗЗХ	-	-

	боловсруулах, хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлэх, системийг байгуулах, хэрэглээнд нэвтрүүлэх;					
21.	Геодезийн цэг, тэмдэгтийн цахим систем байгуулах ажлын даалгавар боловсруулж, холбогдох хурлаар хэлэлцүүлэх, систем хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх;	II-XII	ГЗЗХ	-	-	
22.	Дунд масштабын байр зүйн зургийн цахим систем байгуулах ажлын даалгавар боловсруулах, холбогдох хурлаар хэлэлцүүлэх, систем хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх;	II-XII	ГЗЗХ	-	-	
23.	Техникийн нарийвчлалтай геодезийн хэмжлийн багаж баталгаажуулах жишилтийн полигон байгуулах, хэрэглээнд нэвтрүүлэх;	II-XII	ГЗЗХ	-	-	
24.	GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын хэвийн ажиллагааг хангах, иргэд, аж ахуйн нэгжид шаардлагатай өгөгдөл, мэдээллээр үйлчлэх;	I-XII	ГЗЗХ	-	-	
25.	Газар зүйн нэрийн мэдээллийн цахим систем байгуулах ажлын даалгавар боловсруулж, холбогдох хурлаар хэлэлцүүлэх, батлуулах, систем хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх;	II-XII	ГЗЗХ	-	-	
26.	Тус газрын төрийн архив салбарын хэмжээнд үүссэн цахим архивыг "Архивын цахим" системээр дамжуулан иргэн хуулийн этгээдэд хүртээмжтэй олон төрлийн үйлчилгээг хялбар байдлаар үзүүлэх боломжийг бүрдүүлсэн хөгжүүлэлтийг цахим системд хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;	III	Салбарын архивын хэлтэс	-	-	
27.	Нийслэлийн хэмжээнд Архивын цахим системээр иргэдэд үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд дүүргүүдийн Газар зохион байгуулалтын албаны архивыг цахим системд холбох туршилтыг шат дараатай зохион байгуулах;	III-VI	Салбарын архивын хэлтэс	Баянгол дүүргийн ГЗБА	-	
28.	Системүүдийг бие даасан байдалд шилжүүлэх, сервер, тоног төхөөрөмжийг сайжруулах;	I-IV	ОЗӨДБГ	КХ, ГЗБХ, ГБХ, ГМХ, МТХ	Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системийн өгөгдлийн санг	

					шинэчлэн зохион байгуулж, бие даасан байдалд шилжүүлнэ.
29.	Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх;	I-IV	ОЗӨДБГ	МТХ	Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийн өгөгдлийн санг шинэчлэн зохион байгуулж, хэрэглэгчийн програм хангамжийн хөгжүүлэлтийг хийнэ.
30.	Геопорталаар дамжуулан төрийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтын "Нэг газрын зураг", иргэд, олон нийт, бизнесийн зориулалттай "Нээлттэй газрын зураг" цахим үйлчилгээг улсын хэмжээнд гаргах систем хөгжүүлэлтийн ажил;	I-IV	ОЗӨДБГ	МТХ	Байгууллагуудад зориулсан лавлагаа, Мэдэгдэл хүргүүлэх, зарлан мэдээлэх, Нийлүүлэгч байгууллагуудын ачаалал тэнцвэржүүлэх хөгжүүлэлтийн ажлыг хийнэ.
31.	Газрын биржийн цахим системийн шинэчилсэн 3.0 хувилбарыг хэрэглээнд нэвтрүүлж, иргэнд олон нийтэд нээлттэй ил тод мэдээллээр үйлчлэх;	I-IV	ГБХ	21 аймгийн ГХБХБГ, НГЗБА	-
32.	Газрын биржийн цахим системийн хэрэглэгчдэд зориулсан гарын авлага (ebook)-ийг боловсруулж, нийтийн хүртээл болгох;	I-IV	ГБХ	21 аймгийн ГХБХБГ, НГЗБА	-
33.	Газрын үнэлгээ, төлбөрийн цахим системд нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг хийж иргэд олон нийтэд түргэн шуурхай үйлчлэх боломжийг бүрдүүлэх;	I-IV	ГБХ	21 аймгийн ГХБХБГ, НГЗБА	-
34.	Иргэд, олон нийтийг "Газрын мониторингийн цахим" системээр дамжуулан газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийн мэдээллээр хангах, газар хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний талаарх зөвлөмж өгөх ажлыг зохион байгуулах;	II-IV	ГМХ	21 аймгийн ГХБХБГ, НГЗБА	Иргэд, олон нийтэд "Газрын мониторингийн цахим" системийн газрын төлөв байдал, чанарын өөрчлөлтийн талаарх мэдээллээр хангах, газар хамгаалах

					<p>нөхөн сэргээх арга хэмжээний зөвлөмж өгөх ажлыг зохион байгуулах. Иргэд, олон нийтэд хүргэх мэдээлэл, зөвлөмжийг байгууллагын цахим хуудас болон facebook хуудсаар дамжуулан хүргэнэ.</p>
35.	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн 22 үйлчилгээг "E-Mongolia"-д холбох, хэрэглээнд нэвтрүүлэх;	IV-XII	КХ	-	<p>Газрын харилцаатай холбоотой үйлчилгээг иргэд олон нийтэд хүртээмжтэй хүргэх зорилгоор e-gazag-ын 22 үйлчилгээг e-Mongolia-д холбох</p>
36.	"Засвар, хяналтын модуль"-ийг хэрэглээнд нэвтрүүлж, иргэн хуулийн этгээдийн зөрүүтэй бүртгэгдсэн мэдээллийг засварлуулах ажлыг зохион байгуулах;	IV-XII	КХ	-	<p>Газрын кадастрын мэдээллийн системд өдөр тутамд хийгдэж буй засварыг 21 аймаг, нийслэл, дүүргийн асуудал хариуцсан албан хаагчид гүйцэтгэх, хэрэглэгчийг тухай бүр хянах боломжийг бүрдүүлсэн.</p>
37.	Газрын кадастрын мэдээллийн системд эрх бүхий этгээдийн шийдвэрүүдэд цаасан эх хувийг нөхөн бүрдүүлж, хавсаргах ажлыг зохион байгуулах;	IV-XII	КХ	21 аймгийн ГХБХБГ, НГЗБА	<p>Газрын кадастрын мэдээллийн системд эрх бүхий этгээдийн шийдвэрүүд бүртгэгдэн орсноор иргэн тухайн газартай холбоотой лавлагаа мэдээлэл авахад амар хялбар</p>

					болж цаг хугацаа хэмнэх юм.

—000—